



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

САНХҮҮГАЙН ГЭРЭГ ЗӨВЛӨЛИЙН ДЭГЭЭР ХАРИУУЛАГЧИЙН  
АЖЛАХ АТВА

Улаанбаатар, Засаг захиргаа 10000  
Утас 36-17-44 Факс 36-17-11-329-188  
E-mail: info@sa.gov.mn, www.sa.gov.mn

2017.06.23 № 3/1922

Хөрөнгө актлуулах тухай

Тус Хороонд Төрийн өмчийн хороог татан буулгах комиссын 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 03 тоот шийдвэрийн дагуу Төрийн өмчийн хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 48 нэр төрлийн, 132 тоо ширхэгтэй, 53,760,309.46 /тавин гурван сая долоон зуун жаран мянга гурван зуун есөн төгрөг дөчин зургаан мөнгө/ бүртгэлийн үнэ бүхий тавилга, эд хогшил, компьютер тоног төхөөрөмж балансаас баланст шилжин ирсэн.

Төрийн өмчийн хорооноос хүлээн авсан эдгээр тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн 43 нэр төрлийн 106 тоо ширхэг нь 1996 оноос ашиглалтад орсон, хэрэглээний шаардлага хангахгүй болсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, тавилга, ширээ сандлын хувьд дахин ашиглах боломжгүй, будаг хуулга нь халцарсан, эвдэрхий, угсарч засварлах боломжгүй хөрөнгүүд байна.

Дээрх тавилга, эд хогшил, техник тоног төхөөрөмжийг ажилтан, албан хаагчдын хэрэглээнд ашиглаагүй, хүлээн авсан үеэс одоог хүртэл Хорооны хөрөнгийн агуулахад байгаа бөгөөд агуулахыг цаашид өөр зориулалтаар ашиглах болсон учир суллах шаардлагатай байна.

Иймд Хорооны хагас болон бүтэн жилийн тооллогын комиссын санал, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон, элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн, зарим хөрөнгийн ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад эвдэрч гэмтсэн, сэргээн засварлах боломжгүй болсон, хэрэглээний шаардлага хангахгүй, цаашид ашиглах боломжгүй 43 нэр төрлийн, 106 тоо ширхэг, 40,410,459.46 /дөчин сая дөрвөн зуун арван мянга дөрвөн зуун тавин есөн төгрөг дөчин зургаан мөнгө/ үнийн дүнтэй хөрөнгийг актлуулах хүсэлтэй тул зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэж өгнө үү.

Жич: Хавсралт ..... хуудас хавсаргав.





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

14192 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 81/1,  
Утас: 7011 1090, Факс: (976) 7011 1173

2017.06.30 № A-5/1689

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т. ЖАМБААЖАМЦ ТАНАА**

Танай байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон хавсралтад заасан 28,842,959.46 (хорин найман сая найман зуун дөчин хоёр мянга есөн зуун тавин есөн) төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг үндэслэн актлахыг зөвшөөрч байна.

Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэж дүнг 2017 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА